



ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

Халдлагад өртсөн тухай мэдэгдэх

Хэрэв та “Үндэсний Дата Төв” УТҮГ-ын үйлчлүүлэгч ба мэдээллийн аюулгүй байдлын аливаа зөрчлийн хохирогч болсон, цахим хуудас, сүлжээ тань халдлагад өртсөн гэж үзэж байвал цаг алдалгүй бидэнтэй холбогдохыг хүсье. Мэдээллийн аюулгүй байдлын хувьд тулгарсан асуудал, мэдээллээ хуваалцаж, хамтран шийдвэрлэх нь өөрийгөө болон бусдад учирч болох эрсдэлийг бууруулах учир бага гэлтгүй хамтын хүч, хичээл зүтгэл юунаас ч илүү чухал юм.

Бид аюулгүй байдлын зөвлөгөө, дэмжлэг шаардлагатай үед, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад тань байнга хамтран ажиллах болно.

Халдлага болсон тухай хэн мэдэгдэж болох вэ?

“Үндэсний Дата Төв” УТҮГ-ээс үйлчилгээ авдаг /төрийн/ бүх байгууллагын ажилтан, албан хаагчид, мэдээллийн технологийн мэргэжилтнүүд.

Халдлагын мэдээллийг хэнд өгөх вэ?

Халдлагын тухай мэдэгдэхдээ доорх хаягуудад цахим шуудан илгээнэ үү.

info@dcert.gov.mn

info@datacenter.gov.mn

Яаралтай, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай үед доорх утсаар 7 хоногийн 24 цагийн турш холбогдож болно.

+97670180092

+97670180093

Жич: Мэдэгдэл илгээхдээ PGP түлхүүр ашиглахыг зөвлөж байна. PGP түлхүүрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл энд дарна уу.

Мэдэгдэлд юу тусгах вэ?

- Холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл
- Болсон халдлагын төрөл: Ddos, malware гэх мэт
- Халдлага эхэлсэн хугацаа, огноо
- Халдлагад өртсөн хүрээ
- Халдлага үргэлжилж байгаа эсэх
- Халдлага болж байгааг хэрхэн мэдсэн
- Халдлагын үзүүлсэн нөлөө
- Ямар нэг арга хэмжээ авсан эсэх, авсан бол ямар?
- Танд лог эсвэл өөр ямар нэг мэдээлэл бий юу?
- Авсан бусад арга хэмжээ

Мэдэгдсэний дараа танд

Халдлагын дугаар бүхий тасалбар, мэдээлэл хүлээн авна. Уг дугаараар өөрийн өгсөн мэдэгдэл рүү хандана. Бид таны асуултад хариу өгч, шуурхай ажиллах болно.